

## МОНГОЛ, ОРОС, ХЯТАДЫН ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ӨНГӨРСӨН, ӨНӨӨ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Д.Аюуш\*

***Abstract:** Mongolia, Russia and China have successfully cooperated in many areas. But one of the most important areas of cooperation is trade relations. These relationships often changed over the years, depending on the political relationship. Recently, trilateral commercial cooperation is increasing rapidly in framework of “One Belt, One Road” initiative. The author focuses on making clear the problems in livestock sector, which are arising from Mongolian domestic economic capacity in last 20 years, and find the possible ways to widen agricultural products to export to big neighbour’s market.*

***Key words:** Mongolia, Russia, China, trade, turnover, exports, imports.*

\*\*\*

### Нэг. Ардын хувьсгалын дараах үеийн Монгол, Хятад, Оросын худалдааны байдал

1919 оны байдлаар, Монголд Хятадын 25 гаруй томоохон худалдааны пүүс үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ ихээхэн хэмжээгээр мөнгө хүүлсээр байжээ<sup>2</sup>. Хятадын мөнгө хүүлэх тогтолцоог 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үеэр болон 1912 оны Орос-Монголын хэлэлцээрийн нөлөөн дор халсан байсан боловч амьдрал дээр 1921 оны ардын хувьсгалыг хүртэл байсаар байгаад 1924 онд бүрмөсөн устсан аж<sup>3</sup>.

1921 оны хувьсгалын ялалтаар Монгол улс төрийн тусгаар тогтнолоо олж авч чадсан боловч эдийн засагт харийн капиталын нөлөө хүчтэй байв. Тэр үед улсын гадаад худалдаа бараг бүхлээрээ, дотоод худалдааны ихэнх нь гадаадын, гол төлөв хятадын худалдааны пүүсүүдийн гарт байв. Харин Монгол улсын Ардын засгийн газраас Монгол, Дундад, Орос гурван эдгээдийн ардад нэгэн адил ашиг тус, бүх

\* Доктор (Ph.D), ШУА-ийн ОУХХ-ийн ЭША, ОУХНУС-ийн зөвлөх дэд профессор

<sup>2</sup> Джагаева. Российско-монгольские отношения. Докт. дисс. Элиста. 2006. С.192.

<sup>3</sup> Старицына П. Формы и методы эксплуатации китайского торгово-ростовщического капитала во Внешней Монголии в конце XIXи начале XX века // Труды Московского института востоковедения. 1940, № 42. С.163.

олон улстай худалдаа нэвтрүүлэх<sup>4</sup> талаар анхаарал тавьж эхэлсэн байдаг. Юуны өмнө Монгол Улсын төр, засаг Зөвлөлт Орос Улсаас бүх талын тусламж авч улс орондоо орчин үеийн улс ардын аж ахуйн салбар, соёл, боловсролын тогтолцоог үүсгэн байгуулж, хөгжүүлэхийн төлөө тэмцэж эхэлсэн бөгөөд тусгаар тогтносон Монгол Улсын анхны дипломатууд ч эх орныхоо эдийн засгийн гадаад харилцааг үүсгэн байгуулж, хөгжүүлэхэд идэвхийлэн орсон байдаг юм.

1921 оны есдүгээр сарын 10-ны өдөр Монгол улсын Ардын засгийн газрын ерөнхий сайд, Гадаад яамны сайд Д.Бодоогоос ЗСБНХОУ-ын гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринд Монгол улсаас Хятад улстай найрамдал, худалдааны гэрээ байгуулахад Зөвлөлт Оросыг зуучлан өгөхийг хүссэн нот явуулсан тул зуучилж өгөхийг зөвшөөрсөн хариуг 4 хоногийн дотор өгч байжээ<sup>5</sup>.

1921 оны арваннэгдүгээр сарын 5-ны өдөр Монгол-Зөвлөлтийн найрамдлын гэрээнд гарын үсэг зурснаар Монгол улсын эдийн засгийг сэргээн босгож, хөгжүүлэх зорилтыг тавьсан байдаг. 1922-1925 онуудад Монгол улсаас Холбоот Орос улсад томилогдон очсон анхны элчин сайд нар болох гүн Даваа, Данзан, Буянчуулган нар итгэмжлэх жуух бичгээ барихдаа юуны түрүүнд хоёр улсын худалдаа-эдийн засаг болон соёлын хэлхээ холбоог хөгжүүлэн бэхжүүлэхэд онц анхаарах даалгавартай ирсэнийгээ уламжилж байжээ<sup>6</sup>.

Монгол Улсад орчин цагийн худалдааны систем бүрдэх эхлэл нь 1921 оны арванхоёрдугаар сард Эд хэрэглэгчдийн анхны хоршоог байгуулснаар тавигдсан гэж үздэг байна. 1922 онд Зөвлөлтийн Засгийн газраас зөвлөлт, монголын барааны экспорт, импортыг гаалийн татваргүй болгосон байдаг. 1923 онд Монгол Улсын Ардын Засгийн газар, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улсын Засгийн газрын хооронд манай улсын хувьд анхны худалдааны хоёр талын хэлэлцээрийг байгуулж, хоёр орны барааны эргэлтийг нэмэгдүүлэх, барааг гаалийн хориггүй нэвтрүүлэх, худалдааны төлөөлөгчдийг харилцан суулгах зэрэг чухал асуудлуудыг шийдвэрлэж байжээ. 1923 оны эцэс гэхэд Монголын зах зээл дээр Хятад, Англи, Америк болон Герман улсын нийтдээ 500 гаруй хувийн пүүс үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын бүх экспортын 80 орчим хувийг бүрдүүлж байсан байна. 1924 онд БНМАУ-аас гадаадад гаргасан бүх зүйлийн 86 хувь, гадаадаас оруулсан бүх зүйлийн 87 хувь нь тэдэнд оногдож байжээ<sup>7</sup>.

1924 онд Монгол улсын гадаад худалдаанд ЗХУ-ын эзлэх хувь 13,6 хувь байсан бол, 1928-1929 онд Монголын импортын 73 хувь, экспортын 90 хувьд хүрсэн байдаг<sup>8</sup>.

<sup>4</sup> Монгол-Зөвлөлтийн харилцаа, 1921-1974. Баримт бичиг, материалын эмхтгэл, 1-р боть, 1921-1940. УБ. 1976, 66-69-р тал.

<sup>5</sup> Мөн тэнд.

<sup>6</sup> Монгол-Зөвлөлтийн харилцаа, 1921-1974. Баримт бичиг, материалын эмхтгэл, 1-р боть, 1921-1940. УБ. 1976, 104, 118, 149-р тал.

<sup>7</sup> Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. УБ, 1969, 224-р тал.

<sup>8</sup> Монгольская Народная Республика. "Наука". М., 1971, с.315.

1930 оны 12 дугаар сарын 12-нд болсон БНМАУ-ын Засгийн газрын хуралдаанаас Гадаад худалдааны онц эрхийг тогтоох тухай тогтоол гаргаж, Засгийн газраас баталсан төлөвлөгөө, арга хэмжээг баримтлан экспорт, импортын үйл ажиллагааг явуулж байх үүргийг Худалдаа, аж үйлдвэрийн яаманд хариуцуулжээ. Энэ үеэс эхлэн барааг гадаадаас авах, гадаадад гаргах явдлыг төрийн байгууллага хариуцах болжээ.

1951 онд Монгол, Хятад улсын хооронд худалдааны хэлэлцээр, 1956 онд эдийн засаг, техникийн талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулагдан хятадын барилгын байгууллагын хүчээр үйлдвэр, хөдөө аж ахуй, зам харилцаа, орон сууц, соёл ахуйн томоохон барилга байгууламжууд баригдаж байв. ЗХУ, Хятад Улсын тусламжийн үрээр манай орны үйлдвэрлэх хүч түргэн хурдацтай хөгжиж, 1960 онд аж үйлдвэр дангаараа нийгмийн нийт бүтээгдэхүүний 24,5 хувь, үндэсний орлогын 14,6 хувь, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 50 орчим хувийг үйлдвэрлэдэг боллоо. Үүний дүнд манай орон дан ганц мал аж ахуйн орноос хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болох үндэс тавигдсан юм.

### **Хоёр. Хүйтэн дайны дараах үеийн гурван улсын хоорондын худалдаанд гарсан өөрчлөлт**

1990 онд хоёр улсын хоорондын худалдааны эргэлт 1.2 тэрбум ам. долларт хүрч байв. Энэ үед Монгол Улсын гадаад худалдааны 90 гаруй хувь хойд хөрштэй хийгдэж байв. ЗХУ болон Зүүн Европын орнуудтай улс төр, эдийн засаг, соёлын нягт харилцаатай байсан, Ази тивийн социалист орнуудаас илүү европжсон Монгол оронд энэхүү өөрчлөлт маш хүчтэй хурдан нөлөөлж 1990 онд тайван замаар коммунист үзэл суртал, бодлогоос татгалзан, хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах замыг сонгож, зах зээлийн эдийн засагт шилжих замд Монгол орон орсон юм. 1990-ээд оноос социалист ситем хямралд орж, ЗХУ задарч, социалист орнуудын Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл татан буугдсан нь манай улсын эдийн засаг, түүний дотор гадаад худалдаа-эдийн засгийн харилцааны салбар гүн хямралд өртөж, бүхэлдээ уналтанд орсон хүнд үе эхэлсэн юм. Эл хямрал хэд хэдэн зүйлээс шалтгаалсан байдаг. ХХ зууны 80-аад оны дунд үеэс ЗХУ-ын гадаад бодлого болон гадаад эдийн засгийн харилцааны чиглэлд өөрчлөлт гарч эхэлсэн агаад, энэ нь мөн Монголд хандах сонирхол нь буурч эхэлсэнтэй холбоотой байдаг. Үүний зэрэгцээ хоёр улсад өөрчлөн байгуулалт хийж эхэлсэн байдаг. ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч нь ОХУ болсноор Монголд хандах хандлага нь мөн ОХУ-д өвлөгдсөн байдаг. Энэ үе нь мөн Монголд худалдааны шинэ түншүүдээ хайж байсантай давхцсан байдаг бөгөөд 1990-ээд оны эхнээс хоёр улсын худалдааны нийт эргэлт буурсаар 1998 он гэхэд 183 сая америк долларт хүрсэн бөгөөд үүнээс экспорт 38.4 сая америк доллар, импорт 144.6 сая америк долларт хүрсэн юм. Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн харилцаа сүйрэхэд мөн хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн байдаг. Үүнд:

1. Хоёр улс эдийн засгийн салбартаа гадаадын хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээнгүүдийг авч эхэлсэн;
2. Хоёр улсын дотоодын эдийн засгийн байдал УАА-г чөлөөт эдийн засгийн зах зээлд шилжүүлэх болсноор эрс доройтсон;
3. 1991 оноос хоёр улс хоорондоо чөлөөтэй хөрвөдөг валютаар дэлхийн зах зээлийн үнээр худалдаа хийх болсноор валютын хомсдолд орсон байсан;
4. ОХУ-аас хийх хөрөнгө оруулалт зогссоноор Монголын эдийн засгийн өсөлт зогссон;
5. Монгол Улс эдийн засгийн гадаад харилцааны шинэ түнш хайх болсон; 6. хоёр улсын аж ахуйн хуучин тогтсон байсан харилцаа тасарсан;
7. Хоёр улсад өмч хувьчлал явагдаж, урьдын улсын үйлдвэрүүд үгүй болсоноор худалдааны Монголын уламжлалт хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн экспорт тасарсан;
8. Хуучин ЗХУ-д төлөх өр, зээлийн асуудал шийдэгдээгүй байсан зэрэгтэй холбоотой байв.

### **Монгол Улсын “Их өр”-ийн асуудлыг шийдвэрлэсэн нь**

Монголд олгосон өр зээлийн хэмжээг ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын нэгэн адил хуучин ЗСБНХУ-аас шилжих рублиэр ОХУ-ын Эдийн засгийн яамны дэргэдэх Эдийн засгийн хүрээлэнгээс 1992 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар тооцож гаргасан байв. Уг тооцоог тухайн хоёр орны засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн баримт бичигт тулгуурлан хийсэн байв.

Монгол Улс 1949 оноос хойш хуучин Зөвлөлт Холбоот Улстай байгуулсан 34 удаагийн зээлийн хэлэлцээрийн дагуу нийт 10.05 тэрбум шилжих рублийн зээл авахаар тохиролцсон. Түүнээсээ 9.8 тэрбум шилжих рублийн зээлийг авч ашиглажээ. Зээлийг ашигласан бүхий л хугацаанд нийт 1.06 тэрбум шилжих рублийн хүү бодогдож 235.2 сая шилжих рублийн үндсэн өр, 351.1 сая шилжих рублийн зээлийн хүүг эргүүлэн төлснөөр 1991 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар үндсэн өр 9.57 тэрбум шилжих рубль, хүү 0.7 тэрбум болоод байсан юм. Хэдийгээр Монголын тал 1991 оноос хойш шилжих рублийн зээлд хүү тооцохгүй байх саналыг тавьсаар ирсэн боловч Оросын тал хүлээж авалгүй байсаар 2003 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар дүн 1,4 тэрбум шилжих рублиэр өсөж 2,13 тэрбум шилжих рубльд хүрсэн байлаа. Хүүгийн төлбөр өдөр хоногоор өсөж, жилд дунджаар 100 гаруй сая шилжих рублиэр нэмэгдэж байсан нь хэн бүхний сэтгэл санааг зовоож байсан юм. Зээлийн ашиглалтыг зориулалтаар нь авч үзвэл 5955.5 сая шилжих рубль буюу нийт зээлийн 60.7 хувийг нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх, материаллаг үйлдвэрлэлийн салбарын баазыг бэхжүүлэхэд, 3186.9 сая шилжих рубль буюу 32.5 хувийг гадаад худалдааны тэнцлийг хангах болон импортын

барааны үнийн өсөлтийг нөхөхөд, 652.8 сая шилжих рубль буюу 6.67 хувийг хамтарсан үйлдвэрүүдийн дүрмийн сангийн Монголын талын хувь хөрөнгийг бүрдүүлэхэд тус тус зориулсан байна<sup>9</sup>. Ашигласан нийт зээлийн 50 орчим хувь нь аж үйлдвэрийн салбарт, 30 хувь нь нийгмийн салбарын хөгжилд, 16 хувь нь ХАА-н салбарт, 4 хувь нь тээвэр, холбооны салбарт зарцуулагдсан байна. Нийт зээлийн хөрөнгийн 75 орчим хувийг барилга байгууламжийг “под ключ” хэлбэрээр барихад ашиглажээ. Хуучин ЗСБНХУ-аас авч байсан зээлийн төлөх хугацаа 12 жил, зээлийн жилийн хүү 2 хувь байсан бөгөөд Монголын талын хүсэлтээр өрийн төлбөрийг тогтмол хойшлуулан, зарим хэсгийг нь хүчингүй болгуулж байв. Мөн түүнчлэн 1950-иад оноос 1980-аад оны сүүлч үе хүртэл Монгол улс нь хойд, урд хөрш болох ЗСБНХУ, БНХАУ-ын хоорондын улс төрийн харилцаа ихээхэн муудахад улс төрийн хувьд зөвхөн хойд хөршөөсөө бүрэн хамаарах болсон билээ. Чухам түүхэн улс төрийн ийм нөхцөл байдалд БНМАУ нь ЗСБНХУ-аас ихээхэн хэмжээний зээл авсаар байв. 1990 оноос хойш хоёр улсын хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаанд хүндрэлүүд гарч эхэлсэн нь, **нэгд**, урьдын адил шилжих рублиэр хоорондын тооцоог хийхээ больсноор чөлөөт валютын хомсдолд орсон, **хоёрт**, “Их өр”-ийг төлөх асуудал тавигдах болсонтой холбоотой юм. Ийм хүндхэн нөхцөлд буюу 1995 онд тэр үеийн Монгол Улсын Ерөнхий сайд асан П.Жасрай, ОХУ-ын Засгийн газрын дарга асан В.Черномырдин нар “хоёр орны ард түмний уламжлалт найрамдалт, онцгой дотны харилцаатай явж ирснийг харгалзан үзэж, их өрийн асуудлыг монголын ард түмэнд хүнд дарамт үзүүлэхгүйгээр шийдвэрлэнэ” гэдгийг зарчмын хувьд тохиролцсон нь уг асуудлыг амжилттай шийдвэрлэх үндэс болсон байдаг юм. ОХУ-ын зүгээс их өрийг зохицуулах хувилбаруудыг удаа дараа тавьсаар байв. Тухайлбал:

- ОХУ-ын Засгийн газрын тэргүүний орлогч О.Давыдов 1996 оны 11 дүгээр сард манай улсад айлчлах үеэрээ шилжих рублийн өрийг 1:1 ам. долларт шилжүүлж 85 хүртэл хувиар тэглэх боломж байгааг мэдэгдэж байсан.
- ОХУ-ын Засгийн газрын тэргүүн С.Степашин 1999 оны 6-р сарын 18-нд Монгол улсын Ерөнхий сайд Ж.Наранцацралтад ирүүлсэн захидалдаа, ОХУ-ын “Внешэкономбанк”-ны 1999-01-01-ний тооцоог үндэслэн Монголын өрийг 11,3 тэрбум шилжих рубль байгаа хэмээн дурьдаад, уг өрийн 70 хувийг тэглэж, үлдсэн 30 хувийг 33 жилийн туршид хөнгөлөлттэй хүү тооцон барагдуулах, ингэхдээ шилжих рубль болон ам. долларын итгэлцүүрийг 1:1 гэсэн харьцаагаар тогтоох саналыг тавьсан юм.
- ОХУ-ын Засгийн газрын тэргүүн М.Касьянов 2002 оны 3 дугаар сард манай улсад айлчлах үеэрээ шилжих рублийн өрийг 1:1 ам. долларт шилжүүлж 95 хүртэл хувиар тэглэж, үлдэх 550 сая ам. долларыг 40 жилийн туршид төлөх, 2000-2001 оны урсгал өр болох 10 сая ам. доллараас 6 саяыг нь бэлнээр шилжүүлж, үлдсэн хэсгийг нь бараагаар, тухайлбал, махаар төлөх боломж байгааг мэдэгдэж байв.

<sup>9</sup> Б.Пүрэвсүрэн. “Их өр” үүссэн, дууссан түүх. Улаанбаатар, 2008, 15-р тал.

ОХУ нь Парисын клубт элссэн учраас өр зээлийг тус клубын журам дүрмийн дагуу төлүүлнэ гэж манай талд мэдэгдэж байв. Эдгээр хувилбаруудыг тухайн үед нь манай улсын удирдлагууд хүлээн авч биелүүлээгүй боловч, зарим нэгэн эрх мэдэлтнүүд гаднаас зээл аваад бушуухан их өрийг хаах санал тавьж байлаа.

2003 онд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр Москвад хүрэлцэн ирсэн юм. ОХУ-ын Засгийн газрын дарга М.Касьянов хоёр талын уулзалтын үеэр Оросын тал Монгол Улсын “Ихөр”-ийн 98 хувийг (рубль – долларын итгэлцүүр харьцааг 1,0 : 1,0 –ээр бодож) тэглэж, Монголын тал үлдсэн 250 сая ам. долларыг шууд төлөхөөр эцэслэн тохиролцсон болохыг мэдэгдсэн юм. Энд нэг зүйлийг тэмдэглэж хэлэхэд, манай ҮАБЗ-өөр хэлэлцэж дээр дурьдсан олон улсын практик туршлагын дагуу Чех Улсын “FID group”-ээр дамжуулан их өрийн асуудлыг шийдвэрлэж болох тухай зөвлөмж гаргасан нь асуудлыг шийдвэрлэхэд түргэтгэж өгсөн юм<sup>10</sup>.

### Монгол –ЗХУ (ОХУ), Монгол-БНХАУ-ын худалдааны эргэлт (хувиар)<sup>11</sup>

Монгол-Оросын худалаа				Монгол-Хятадын худалдаа			
Он	Гадаад худалдааны эргэлт	Нийт дүн	Экспорт	Импорт	Нийт дүн	Экспорт	Импорт
<b>1951</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100,0</b>	<b>100</b>	<b>0,0</b>	<b>0,0</b>	<b>0,0</b>
<b>1952</b>	<b>100</b>	<b>98,9</b>	<b>99,0</b>	<b>98,9</b>	<b>1,1</b>	<b>1,0</b>	<b>1,1</b>
1953	100	98,5	97,2	100	2,5	3,7	1,1
1954	100	97,3	98,3	96,2	2,7	1,7	3,8
1955	100	96,1	96,6	95,6	3,9	3,4	4,4
1956	100	91,3	92,9	90,0	8,7	6,3	10,7
1957	100	80,3	82,9	78,2	12,4	7,8	15,9
1958	100	69,8	77,7	64,0	16,0	5,0	24,2
1959	100	67,2	76,1	60,6	15,0	4,3	22,9
1960	100	72,5	73,7	71,9	3,3	5,6	2,0
<b>1961</b>	<b>100</b>	<b>77,2</b>	<b>70,0</b>	<b>81,5</b>	<b>9,4</b>	<b>8,2</b>	<b>10,0</b>
1962	100	73,4	65,2	78,8	9,4	10,5	8,7
1963	100	79,7	75,6	82,0	2,0	0,8	2,6
1964	100	76,8	73,2	79,7	3,0	4,2	1,9
1965	100	79,2	73,7	83,4	1,4	1,1	1,6
1966	100	78,2	72,4	84,0	0,6	0,2	0,2
1967	100	77,9	70,3	82,9	0,8	1,0	0,6
1968	100	77,9	70,3	82,9	0,8	1,0	0,6
1969	100	77,5	68,1	84,1	0,7	1,4	0,3
1970	100	75,7	68,4	80,9	1,2	2,0	0,7
1971	100	77,2	73,4	80,4	1,6	1,6	1,6

<sup>10</sup> Мөн тэнд, 98-99-р тал

<sup>11</sup> Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

1972	100	76,5	71,1	81,0	1,8	2,2	1,5
1973	100	76,2	69,2	81,2	1,8	2,2	1,6
1974	100	77,8	76,4	79,0	1,1	1,3	1,0
1975	100	78,5	77,4	79,3	1,1	1,1	1,0
1976	100	79,8	78,3	80,7	0,8	0,2	0,7
1977	100	78,4	72,8	82,6	1,4	1,3	0,8
1978	100	78,4	75,0	81,1	1,2	1,4	1,1
1979	100	80,4	77,4	82,9	1,1	1,1	1,1
1980	100	83,0	79,3	85,8	0,8	0,9	0,7
1981	100	85,6	82,8	87,5	0,4	0,5	0,4
1982	100	85,1	82,4	87,1	0,4	0,4	0,3
1983	100	84,7	81,2	87,0	0,3	0,4	0,3
1984	100	84,2	80,2	86,9	0,3	0,4	0,3
1985	100	83,1	77,0	86,9	0,4	0,4	0,4
1986	100	82,3	75,5	86,8	0,7	0,4	0,8
1987	100	83,6	78,0	87,2	1,1	0,5	1,4
1988	100	81,8	75,6	86,0	0,9	0,4	1,2
<b>1989</b>	<b>100</b>	<b>78,7</b>	<b>77,0</b>	<b>79,9</b>	<b>1,4</b>	<b>0,6</b>	<b>2,1</b>
1990	100	78,2	78,6	77,9	2,3	1,7	2,7
1991	100	72,0	68,3	75,6	10,4	16,3	4,7
1992	100	54,9	57,3	52,6	17,4	18,8	16,1
1993	100	56,4	53,1	59,6	26,0	31,8	20,1
1994	100	42,4	29,9	59,7	17,9	21,2	13,4
1995	100	31,2	14,6	50,1	14,8	17,1	12,2
1996	100	27,7	20,6	34,4	17,6	19,8	15,4
1997	100	20,5	8,2	35,4	16,3	18,2	14,1
<b>1998</b>	<b>100</b>	<b>19,8</b>	<b>8,8</b>	<b>29,8</b>	<b>18,4</b>	<b>24,0</b>	<b>13,2</b>
<b>1999</b>	<b>100</b>	<b>20,5</b>	<b>10,6</b>	<b>29,2</b>	<b>29,6</b>	<b>45,8</b>	<b>15,1</b>
2000	100	21,8	8,4	33,6	34,8	51,2	20,5
2001	100	22,0	7,5	35,4	30,3	40,0	21,4
2002	100	23,5	9,2	34,4	31,9	42,8	24,2
2003	100	21,8	6,7	33,6	33,6	46,6	23,6
2004	100	19,2	2,4	33,5	35,4	47,6	25,1
2005	100	19,9	2,6	35,5	36,4	48,2	25,8
2006	100	19,9	2,9	38,2	47,5	68,1	25,4
2007	100	20,0	3,0	36,1	49,4	72,5	27,6
2008	100	23,0	3,4	38,3	43,9	64,5	27,7
2009	100	20,9	3,6	36,2	48,0	73,9	25,2
2010	100	18,5	2,8	32,7	56,4	84,8	30,5
2011	100	15,1	2,0	24,6	56,7	92,2	30,8
2012	100	17,3	1,8	27,4	53,3	92,6	27,8
2013	100	15,3	1,4	24,6	52,0	86,8	28,7
<b>2014</b>	<b>100</b>	<b>14,6</b>	<b>1,1</b>	<b>29,6</b>	<b>62,1</b>	<b>87,9</b>	<b>33,8</b>
2015	100	13,0	1,6	26,9	62,6	83,7	36,6

2016	100	11,3	1,1	26,2	60,0	79,4	31,6
2017	100	12,2	1,1	28,1	63,9	85,6	32,9
<b>2018</b>	<b>100</b>	<b>13,9</b>	<b>1,2</b>	<b>29,1</b>	<b>66,1</b>	<b>93,3</b>	<b>33,5</b>

Дээрх хүснэгтээс харахад, 1990 онд Монгол-ЗХУ-ын худалдаа нийт гадаад худалдааны 78.2 хувийг, үүнээс экспорт 78.6 хувь, импорт 77.9 хувь байсан бол 2018 онд Монгол-ОХУ-ын худалдаа нийт гадаад худалдааны 13.9 хувийг, үүнээс экспорт 1.2 хувь, импорт 29.1 хувь болсон байна. 1990 онд Монгол-БНХАУ-ын хоорондын худалдаа нийт гадаад худалдааны 2.3 хувийг, үүнээс экспорт 1.7 хувь, импорт 2.7 хувь байсан бол 2018 онд Монгол-БНХАУ-ын худалдаа нийт гадаад худалдааны 66.1 хувийг, үүнээс экспорт 93.3 хувь, импорт 33.5 хувь болсон байна.

### Гурав. Монгол, Орос, Хятадын хоорондын худалдааны өнөөгийн байдал

**Монгол-Оросын худалдаа:** 2018 онд хоёр улсын хоорондын худалдааны нийт эргэлт **1.79** тэрбум америк долларт хүрч, **0.5** тэрбум ам.доллараар өссөн байна, үүнээс экспорт **85.9** сая америк доллар, импорт **1.71** тэрбум америк доллар болжээ.

**Монгол-Хятадын худалдаа:** 2018 онд хоёр улсын хоорондын худалдааны нийт эргэлт **8.53** тэрбум америк долларт хүрч, **1.8** тэрбум ам.доллараар өссөн байна, үүнээс экспорт **6.54** тэрбум америк доллар, импорт **1.96** тэрбум америк доллар болжээ.

### Монгол Улсаас ОХУ, БНХАУ- тай хийсэн худалдааны импорт, экспортын хэмжээ:

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2016	2017	2018
<b>Импорт</b>										
БНХАУ	125.8	138.2	172.1	198.2	262.2	303.2	368.2	1 061.2	1 427.7	1968.8
ОХУ	206.2	226.0	237.6	265.4	341.9	417.9	547.8	880.4	1 219.2	1 710.3
<b>Экспорт</b>										
БНХАУ	274.4	238.3	220.5	287.0	413.9	513.2	1 049.4	3 901.6	5 307.4	6 542.8
ОХУ	45.1	44.9	48.0	41.2	20.6	27.2	45.1	55.8	67.7	85.9

### 2019-I-VII сарын байдлаар

Монгол Улсаас БНХАУ руу нийт экспортын 42.4 хувь нь 20.4 сая т чулуун нүүрс, 29.0 хувь нь 867.7 мянган т зэсийн баяжмал, 7.5 хувь нь төмрийн хүдэр, баяжмал, 21.1 хувь нь бусад бараа, бүтээгдэхүүн гаргасан байна. БНХАУ-аас Монгол Улс руу нийт импортын 11.3 хувь нь 2 657 ш ачааны тэрэг, 6.1 хувь нь 774.0 сая кВт цаг цахилгаан эрчим хүч, 3.4 хувь нь 610 ш бульдозер, экскаватор, зам индүүдэгч зэрэг, 79.1 хувь нь бусад бараа бүтээгдэхүүн оруулсан байна. Монгол Улсаас ОХУ



руу нийт экспортын 80.4 хувь нь 110.0 мянган тн жонш, 10.8 хувь нь 6.4 мянган тн газрын тосны бүтээгдэхүүн, 1.1 хувь нь 2 ш тусгай зориулалтын машин механизм,, 7.7 хувь нь бусад бараа, бүтээгдэхүүн гаргасан байна.ОХУ-аас Монгол Улс руу нийт импортын 63.8 хувь нь 986 мянган тн нефтийн бүтээгдэхүүн, 4.3 хувь нь 75.9 мянган тн арматур, цувимал төмөр, 2.2 хувь нь 74.1 мянган тн азотын бордоо, 29.7 хувь нь бусад бараа бүтээгдэхүүн оруулсан байна<sup>12</sup>.

### **Дөрөв. Гурван улсын хоорондын худалдааны хөгжлийн цаашдын төлөв**

Өнөөгийн байдлаар Монгол Улс хоёр хөрш оронтойгоо хамгийн их худалдаа хийж байгаа бөгөөд, экспортонд эрдэс бодис, уул уурхайн бүтээгдэхүүн гаргаж байна. Монгол Улсаас ОХУ-тай хийж байгаа худалдаа алдагдал ихтэй байна. Одоогоор ОХУ Монголоос ихэвчлэн хайлуур жонш авснаар хязгаарлагдаж байна. Монгол Улсаас жилдээ 100.0 мянган тн үхрийн мах нийлүүлэх бололцоотой гэдэг боловч, хэд хэдэн хүчин зүйлээс болж мах экспортлох боломжгүй байгаа юм. Үүнд:

1. Оросын мал эмнэлгийн албанаас хэд хэдэн шаардлага тавьсаар ирсэн байдаг. Эдгээрт,
  - Малаа эрүүлжүүлж, дэлхийн мал эмнэлгийн албанаас гэрчилгээ авсан байх.
  - Сүүлийн 3 жил дараалан малын өвчин гараагүй аймаг, сумаас малын махыг гаргана
  - ОХУ-ын хилээр амьд малыг хөлөөр нь оруулахгүй.
  - Хонины махыг авахгүй
  - Үхрийн ясгүй хөлдөөсөн махыг Уралын нурууг хүртэлх хотуудын мах, консервын үйлдвэрт авах бөгөөд жижиглэнгээр худалдахыг зөвшөөрөхгүй гэдэг

Эдгээр шаардлагаас гадна мөн мал, мах, тэдгээрийн арьс, шир, ноос, ноолуур, түүгээр хийсэн бүтээгдэхүүнд ОХУ-ын мал эмнэлгийн албанаас хатуу шаардлага тавьж, өндөр татвар ногдуулдаг. Нөгөөтэйгүүр, социализмын үед зөвхөн Монголоос жил бүр 2 сая хүртэл толгой бод, бог мал амьдаар нь авч байсан үеийг бодвол өдгөө байдал огт өөр болж ОХУ үхэр, гахай, шувууны махыг өөрсдөө дотооддоо өсгөн үржүүлж байна. 1990-ээд оноос хойш ОХУ-ын импортоор авах махны хэрэгцээ нь 4.5 сая тн , үүнээс үхрийн махных 1.5 сая тн байсан бол одоо гахай, шувууны махаа дотооддоо хангадаг болсон бөгөөд зөвхөн үхрийн махны импортын хэрэгцээ 300 мянган тн байгаа юм. Харин ОХУ-ын махны зах зээлийг нь Латин Америкийн Бразил зэрэг орнууд монополичилж авсан байдаг. Тэдгээр орноос оруулж буй үхрийн махтай манай махны өрсөлдөх чадвар ямар байна вэ ?

<sup>12</sup> Үндэсний статистикийн хороо. www.1212.mn

**Нэгд**, ОХУ-ын мал эмнэлгийн албаныхан Монголын мал аж ахуй бэлчээрийнх учраас малын гоц халдварт өвчин дэгдэх эрсдэл ихтэй гэж үздэг бөгөөд малын өвчинг устгаж, Дэлхийн мал эмнэлгийн албанаас Монголд малын гоц халдварт өвчин байхгүй гэсэн сертификат авсан байх ёстой.

**Хоёрт**, манайд хөлдөөсөн ясгүй үхрийн цул махыг жилийн 4 улиралд тасралтгүй нийлүүлэх боломжгүй, тийм уламжлал байхгүй.

**Гуравт**, Монголоос мах импортоор оруулах асуудлыг ОХУ-ын хил, бүс нутгийн субъектүүд дангаараа шийдвэрлэх эрх мэдэлгүй байдаг бөгөөд жил бүрийн импортын хэмжээ, квотыг Москвагаас хуваарилж, зөвшөөрөл олгодог.

**Дөрөвт**, Монголын үхрийн цул махны дотоодын зах зээлийн үнэ 5 америк доллар байгаа нөхцөлд Бразилийн хөлдөөсөн ястай, ясгүй үхрийн махны бөөний үнэ ОХУ-д дунджаар 2.2 америк доллар байна. ОХУ-ын дотоодын жижиглэнгийн үнэ алслагдсан нутагт нь 10 америк доллартай тэнцдэг.

**Тавд**, махны бүтцийг нь авч үзвэл, монгол малын мах хатуу, шөрмөслөг, өөхөн давхрага нь гаднаа байхад, латин америкийн махны өөх тос нь махныхаа завсарт алагласан, зөөлөн байдаг байна.

Ийнхүү Монголын үхрийн махны өрсөлдөх чадвар доогуур байгаа учраас Оросын удирдлагатай уулзах болгондоо манайхаас мах аваач гэж гуйхдаа дээр дурьдсан нөхцөл, байдлыг сайн бодолцох ёстой юм.

Монголоос ОХУ-д нийлүүлж буй бараа нийт экспортын 1.3 хувьтай тэнцэж байгаа нь хоёр улсын хоорондын худалдаа туйлын хангалтгүй, монголчуудын хариуцлагатай бас холбоотой юм. Умард хөрштэйгээ тогтоосон эдийн засгийн харилцаа нь сул, худалдаа нь маш их алдагдалтай байгаа нь монголчуудын идэвх санаачлага бага, орос хэлийг төгс эзэмшсэн хүн бараг байхгүй, мэргэжлийн яриа, хэлэлцээ хийхээр бэлтгэгдсэн боловсон хүчнээр дутагдалтай байгаа зэрэг нь бас их нөлөөлж буй. Бага зэрэг ярианы хэлтэй, олон улсын харилцааны тусгай мэдлэг, мэргэжилгүй, хэлэлцээний ур чадваргүй хүнд чухал ажлыг хариуцуулснаас хүсэл, зорилгоо гадны мэргэжлийн хүмүүст тайлбарлаж, ойлгуулж, ярьж чадахгүй аргаа бараад салаавч үзүүлдэг нөхөд байгаа цагт бид зорилгодоо хүрч чадахгүй. Иймд маш сайн орос хэлний мэдлэг, чадвартай, олон улсын харилцааны мэргэжилтнийг зориуд, яаралтай бэлтгэх шаардлагатай байна.

БНХАУ-ын хувьд мөн адил мал эмнэлгийн өндөр шаардлага тавьдаг. БНХАУ-руу үхрийн мах оруулахад мөн эрүүл мэндийн баталгаа шаарддаг, хонины махыг бас оруулахыг хориглодог. Урд хөрш рүү хойд хөршийн нэгэн адил адууны болоод ямааны мах бага зэрэг оруулж байгаа. Үхрийн махыг манай нутаг дээр халуун аргаар боловсруулаад, урд хөрш гаргаж буй. Энэ ажил манай иргэдийн зүгээс хятадууд махны дотоодын зах зээлийн үнийг хөөрөгдөж байна, амьд малтай зүй бусаар харьцаж байна гэх зэргээри маш их хэл ам хийхэд хүргэж байна.

Монголын малыг эрүүлжүүлж чадвал хоёр хөрш оронд болоод дэлхийн бусад

улс оронд экологийн хувьд цэвэр бөгөөд эрүүл малын түүхий эд, мах болон түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжтой болох юм. Ийм нөхцөлд сүүлийн үед Монгол Улсын Засгийн газар ХАА-н салбарыг орчин үеийн цаг үетэйгээ тохирсон салбар болгон хөгжүүлэхээр шийдвэрлээд байна. Тухайлбал, Монголын мал эмнэлгийн асуудалд ихээхэн анхаарал тавихаар болсон бөгөөд тус улсын малыг эрүүлжүүлж, малын гоц халдварт өвчинөөс ангижруулан, урьдчилан сэргийлэх зорилгоор зөвхөн нэг улсаас буюу олон жил энэ салбарт хамтран ажиллаж ирсэн ОХУ-аас малын өвчний эсрэг вакцин авч байх шийдвэр гаргаад байна.

Монгол улсад үнээний сүүний орчин үеийн үйлдвэрлэл сайн хөгжөөгүй байгаа учраас их хэмжээний хуурай сүүг бусад орноос, түүний дотор БНХАУ-аас оруулж байна. Монголд шингэн сүүг орон нутагт цуглуулан хөргөж, үйлдвэрт хүргэж хадгалах, шингэн сүү болон хуурай сүү боловсруулах үйлдвэр байгуулах боломж их байна.

Иймд Монгол Улсын Засгийн газраас мөн дотооддоо ард түмний хэрэгцээг сүүгээр бүрэн хангах зорилтыг тавиад байна. Энэ салбарт Беларусь улстай хамтран ажиллахаар төлөвлөөд байна. Тус улсын ХАА-н салбар нь, үүний дотор сүүний үйлдвэрлэл нэлээд сайн хөгжсөн байдаг. Дээрхээс харахад Монгол Улсад малыг эрүүлжүүлж, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд ОХУ-тай, сүүний чиглэлийн аж ахуйг хөгжүүлэхэд Беларусь улстай хамтран ажиллахаар тохиролцоод байна.

Монгол БНХАУ ХАА-н ямар салбарт хамтран ажиллах ямар боломж байгааг авч үзье.

Монголын 66 сая гаруй малын 60 шахам сая нь хонь, ямаа байна. 30 гаруй сая хонины махнаас хоёр хөрш авахгүй байгаа тул энэ их нөөцийг хааш нь гаргах вэ гэсэн асуулт тавигдаж байна. Монгол Улсад орчин үеийн махны үйлдвэрүүдийг байгуулах шийдвэр гарлаа. Хонины махыг ихээр хэрэглэдэг ард түмэн хаана байна вэ гэвэл монголчуудаас өөр исламын шашин, зан заншилтай улс орнууд байна. Тэд хонийг тусгай исламын шашны халал хэмээх ёсоор нядалж бэлтгэдэг. Тухайлбал, цусыг нь юулж, асгадаг. Ингэж бэлтгэсэн хонины махыг шарж, болгосны дараа яг тахианы мах шиг харагддаг байх жишээтэй. Иймд Монголд мусульманы халал аргаар хонь малыг нядалж, боловсруулдаг орчин үеийн үйлдвэрүүдийг гурван улсын хөрөнгө оруулагчдын оролцоотойгоор барьж, ашиглах шаардлагатай байна. Эдгээр үйлдвэрийг Монголын баруун хязгаарт байгуулж, цаашид мусульман шашинтай Шинжаан-Уйгарын ӨЗО, Киргиз, Казахстан, Баян-Өлгийтэй ойрхон байршуулах хэрэгтэй, мөн Узбекистан, Турк, Азербайжан, Туркменистан, Тажикистан, улмаар арабын орнуудад гаргах боломжийг бий болгох ёстой юм.

ХАА-н салбарын хамтын ажиллагааны бас нэг хэлбэр нь төмс, хүнсний ногооны салбар юм. Манай оронд төмс, хүнсний ногоог ил талбайд болон хүлэмжинд тарьж ургуулах нөөц бололцоо их байна. Монголд жилийн ихэнх хоногт нартай, хөрсийг олон зуун жил ашиглаж, үржил шимийг нь муутгаагүй, харьцангуй усаар хангах

боломжтой. Ийм учраас орчин үеийн техник, технологийг ашиглаж төмс, хүнсний ногоог тарьж, ургуулж, удаан хугацаагаар хадгалах сүүлийн үеийн хүлэмжийн болон зоорины аж ахуйг барьж, байгуулахад мөн хөрш орны хөрөнгө оруулагчдыг татах боломжтой.

Энд ямар учраас төмс, хүнсний асуудлыг яриад байна вэ гэвэл Монгол Улс хүнсний аюулгүй байдлаа сайжруулах, дотооддоо тарьж, ургуулах зорилтыг тавьсан байгаа. Нөгөө талаас, ОХУ-д төмсний хангамж багасаж, түүнийг алс холын Египет улсаас оруулсаар байна.

Төмс, хүнсний нарийн ногооны хувьд зөвхөн дотоодын зах зээлийг хангаад зогсохгүй, мөн дэлхийн бусад улс орныг нэн ялангуяа органик бүтээгдэхүүнээр хангах эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдсээр байгаа явдал юм. Тухайлбал, Англид жилдээ 300 мянган тн органик бүтээгдэхүүн хэрэгтэй байгаа аж.

Органик бүтээгдэхүүн гэж юу вэ? Органик бүтээгдэхүүнийг тарьж ургуулдаг фермерүүд нь экологийн цэвэр аргыг хэрэглэж ногоогоо тарьж ургуулдаг байх ёстой. Энэ нь юу гэсэн үг вэ? гэвэл тариачид синтетик химийн бордоо, мэрэгчид болон шавьж устгах хорт бодиснууд (пестицид, фунгицид, гербицид) ашиглалгүй экологийн цэвэр, аюулгүй материал, технологийг ашигладаг болох ёстой юм. Өөрөөр хэлбэл, органик хөдөө аж ахуй нь эрүүл, амттай, аминдэм ихтэй төмс, хүнсний ногоог арчилж, ургуулах хуучины болоод шинэлэг аргуудыг хэрэглэдэг болох ёстой юм. Иймд тусгай гэрчилгээтэй хүнсний, боловсруулах, үйлдвэрүүд болон жижиглэнгийн худалдааны байгууллагууд органик хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэгдлийг хангаж байх ёстой болоод байна.

ХАА-н гол зорилго нь хоорондоо холбоо бүхий хөрс, ургамал, амьтан болон хүний эрүүл мэндийн байдал ба бүтээмжийг сайжруулахад оршидог.

Хүнсний ногоог орчин үеийн аргаар савлаж, хөлдөөж хадгалах, хатаах, давслах, даршлах, нөөшлөх зэрэг технологийг нэвтрүүлэх талаар хамтран ажиллах хэрэгтэй байна. Тэгэхлээр Монголд органик ХАА-г хөгжүүлэхэд мөн хөрш улс орнуудын хамтын ажиллагаа шаардлагатай байна. Үүнээс гадна Монголын малын түүхий эдийг боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадагш гаргахын тулд мөн орчин үеийн үйлдвэрүүдийг байгуулах хэрэгтэй болоод байна. Монгол Улсын Засгийн газраас саяхан гаргасан бас нэгэн шийдвэрийн дагуу хөдөө, орон нутагт орчин үеийн усалтын системийг байгуулж, тэжээлийн ургамлыг ихээр тарьж ургуулах зорилтыг тавьсан. Энэ салбарт хөрш оронтойгоо хамтран ажиллах явдал чухал болоод байна.

## ДҮГНЭЛТ

Дээр хөндөж ярьсан зарим асуудлыг Монголд хэрэгжүүлэхэд гадаадын, ялангуяа хөрш орнуудаас хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллах шаардлагатай байгаа тул боломжийг эрж хайх хэрэгтэй байна. Үүний тулд Хятад, Оросын хөрөнгө оруулагчдыг эрэн хайн олж, хөрөнгийг нь Монголд татан оруулах хэрэгтэй байна. Тухайлбал, Хятадын хөрөнгө оруулагчдаас гадна Оросын олигархууд АНУ, Их Британ болон барууны бусад орнуудаас хөрөнгө мөнгөө гаргаж эхэлсэн байгааг ашиглах хэрэгтэй байна. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын “**Эдийн засгийн коридор**” байгуулах хөтөлбөрийн дагуу гурван талын “Хөрөнгө оруулалтын зураг төслийн хамтарсан төв”-ийг Улаанбаатар хотноо байгуулахаар болсон. Энэхүү хөтөлбөрт тусгасан 32 төслийг хэрэгжүүлэх төслүүдийг хоёр талтай тохиролцож, ТЭЗҮ-г боловсруулж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

- Япон, АНУ, БНСУ, Канад зэрэг **гуравдагч хөрш орнуудтай** харилцаагаа хөгжүүлэхийн төлөө ажиллаж байна. 2016 оны зургадугаар сараас “Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр”-ийг хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. “Хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд хамтарсан хороо, 13 дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, хоёр тал байнга зөвлөлдөж байна.

Мөн БНСУ болон Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллаж байна. 2016 оны 10 дугаар сард Монгол Улс, БНСУ-ын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах Хамтарсан судалгааны багийн ажлын даалгаварт хоёр тал гарын үсэг зурж, хамтарсан судалгааны ажлын хэсгийн анхдугаар уулзалтыг /12 дугаар сар/ амжилттай зохион байгуулжээ. Түүнчлэн Монголын экспортын бүтээгдэхүүн уламжлалт зах зээл болох ОХУ, Беларусь, Казакстан, Кыргыз, Армений зах зээлийн тариф, тарифын хориг саадыг бууруулах, арилгах үүднээс Евразийн Эдийн засгийн холбоотой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааг эхлүүлэхээр тохиролцоод, 3 удаагийн яриа хэлэлцээ хийгээд байгаа бодит үр дүнд хүргэх нь чухал юм..

### **НОМ ЗҮЙ**

1. Джагаева О.А. Российско-монгольские отношения. Докт. дисс. Волгоград. 2006. С.192.
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх.1-3-р боть, УБ, 1969
3. Монгол-Зөвлөлтийн харилцаа, 1921-1974. Баримт бичиг, материалын эмхтгэл, 1-2-р боть, УБ. 1976. 104, 118, 149-р тал.
4. Монгольская Народная Республика. “Наука”. М., 1971.
5. Монгол-Оросын ХЭЗШУТ-ийн хамтын ажиллагааны ЗКХК-ын хуралдааны материалууд. 1992-2019.
6. Монгол Улсын статистикийн эмхэтгэл. Улаанбаатар хот. 2000-2018.
7. Б.Пүрэвсүрэн. “Их өр” үүссэн, дууссан түүх. Улаанбаатар, 2008, 15-р тал.
8. Старицына П. Формы и методы эксплуатации китайского торгово-ростовщического капитала во Внешней Монголии в конце XIX и начале